

БАТЛАВ
ДОРНОД АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ХӨДӨӨ АЖ АХУЙН САНГААС ХИЛ ХАМГААЛАХ
ТУСЛАХ ХҮЧИНД ДАЙЧЛАГДАН АЖИЛЛАЖ БАЙГАА МАЛЧИН ӨРХИЙН
БЭЛЧЭЭРИЙН УСАН ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ, ДЭМЖЛЭГ
ҮЗҮҮЛЭХ ЗОРИЛГООР ХУДАГ УСТ ЦЭГ, ЦООНОГ ГАРГАХ
АЖЛЫН ДААЛГАВАР

- Байршил:
 - Халхгол сум, Ташгай 3 дугаар баг, Авдрант
 - Халхгол сум, Ташгай 3 дугаар баг, Задгайт зэрэг байршлын ойролцоо усны ундарга сайтай газар гүн өрмийн цооног тус тус гаргана.
- Худгийн цооног гаргахад тавигдах шаардлага:


Уст цэг, цооног гаргах ажлыг “Худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах ажилд тавих техникийн шаардлага” MNS 6088:2010 стандартын дагуу “Усны мэргэжлийн байгууллага” хийж гүйцэтгэнэ.


№	Үзүүлэлтүүд
1. Цооног өрөмдөх, тоноглох, шавхалт	
1.1	Геофизикийн судалгаа хийж, худгийн байршлыг эцэслэн тогтоох
1.2	Өрөмдмөл худгийн цооногийн ашиглалтын ундрага нэг цагт 2 м ³ -ээс 6 м ³ ус өгөх хүчин чадалтай байна.
1.3	Суултын болон шүүрийн яндангийн материал нь ган буюу зөвшөөрөгдсөн хуванцар яндан байна.
1.4	Ус өргөх ган буюу зөвшөөрөгдсөн хуванцар яндангийн диаметр 32 мм байна.
1.5	Цооног дахь суултын яндан, шүүр нь 20-иос доошгүй жил ашиглах нөхцлийг хангасан байвал зохино.
1.6	Ус шүүх хайрга нь шигшсэн, мөлгөр хэлбэртэй, тоосонцор хольцгүй, мөхлөгийн хэмжээ 9 мм-ээс томгүй байна.
1.7	Цооногийн ундрага 1.5 л/секундээс дээш.
1.8	Цооногийн шавхалт хийж хугацаа 24 цаг байна.
1.9	Цооногийн уснаас дээж авч шинжилгээ хийлгэсэн байна.
1.10	Цооногийг түр хугацааны аюулгүй байдлын шаардлага хангасан тагаар тоноглох шаардлагатай.
2. Цооногийн насос, цахилгааны утас, хянах самбар	
2.1	Цооногийн ус шахуурга : Гүний насос: ISO9001 стандартын шаардлага хангасан. Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой байна. Гарал үүслийн гэрчилгээтэй, үйлдвэрлэгчийн нэр, хаяг, барааны олон улсын гэрчилгээтэй байна.
2.2	Цахилгааны утас нь худагт ашиглах шаардлагыг хангасан 3 фазын, насосноос хянах самбар хүртэл үргэлжилсэн (залгаасгүй), ус өргөх янданд 2м тутамд хавчиж тогтооно.
2.3	Хянах самбар нь асаах, унтраах товчлууртай байна. Насос ажиллаагүй


	байх үед ногоон гэрэл, хүчдэл өгч ажиллах байх үед улаан гэрэл асаж байхаар тохируулна.
3. Гүн өрмийн цооног гаргах ажлыг дуусгаж хүлээлгэж өгөх	
3.1	Талбайг цэвэрлэх: /өрөмдлөгийн шлам, цементийн баглаа боодол, хайрга чулуу болон ахуйн хог хаягдал гэх мэт/
3.2	Гүний өрмийн насосыг ажиллуулах талбайн сургалтыг ашиглагч нарт хийсэн байна.
3.3	Цооногийн паспортыг 2 хувь бэлтгэж баталгаажуулан сумын Засаг даргын тамгын газарт хүлээлгэж өгнө.


Монгол Улсын Хөдөө аж ахуйн сайд, Байгаль орчны сайд, Сангийн сайдын 2005 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн 101, 189, 194 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэг журам"-ыг мөрдөнө.

ХЯНАСАН:


АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН,
ХЭЛТСИЙН ДАРГА  М.НЯМСҮРЭН

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН  Г.БАЯРСАЙХАН

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН  С.СОЛОНГО

АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Д.МӨНХБАЯР

БОЛОВСРУУЛСАН:

АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН МАЛ
ҮРЖЛИЙН АЛБАНЫ ДАРГА  Д.НАРАНХҮҮ